

ОЮУН СУДЛАХУЙН НАЙМАН БАДАГ

1. Би бээр хамаг амьтдыг
Чандмань эрдэнээс ч үлэмж
Үнэнхүү дээд тусыг бүтээх сэтгэлээр
Үргэлж энхрийлэх болтугай
2. Хаана, хэнтэй ч нөхөрлөсөн
Өөрийгөө бусдаас доор үзэж
Өрөөлийг чин сэтгэлээр
Өндөрт эрхэмлэн дээдлэх болтугай
3. Явдал бүгдийг сэтгэлдээ шинжлэх ба
Ямагт нисваанис төрсөн даруйд
Өөрийг ба бусдыг доройтуулах тул
Өнөд түүнийг хүчлэн буцаах болтугай
4. Авир чанар муут нэгэн бээр
Аймшигт хилэнц, зовлонд нэрвэгдэхийг
Олж харсан даруйдаа эрдэнийн сантай учирсан мэт
Олдохуйяа бэрх түүнийг энхрийлэх болтугай
5. Надад бусад бээр атаархаж
Гүтгэн буруутгах зохисгүй бүгдийн
Хохирол бүгдийг өөртөө авч
Ашиг бүгдийг тэдэнд өргөх болтугай
6. Миний тусласан нэгэн бээр
Миний найдсан тэр бээр
Машид зохисгүй хорлол үйлдэхэд
Магадтайяа буяны садан дор харах болтугай
7. Товчилбоос, шууд ба дам алинаар
Тус амгаланг үлдээлгүй бүгдэд өргөө
Эх тэдний хорлол, зовлон бүгдийг
Би өөртөө нууцлан авах болтугай
8. Эдгээр бүгдийг найман номын
Эндүү атгагийн хирээр үл бохирдуулж
Юмс бүгдийг илбэ дор мэдэх билгүүнээр
Шунал үгүй еэ хүлээснээс гэтлэх болтугай